СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/88/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Миндүг Аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал С.Энхтөр<br>Утас: 95957791<br>Цахим хаяг: director@mindug.mn<br><br>Аудитын менежер Ц.Номингоо<br>Утас: 90098901<br>Цахим хаяг: coo@mindug.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....................3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....................5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....................10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....................10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 411
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд......11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................13
4. АУДИТЫН ТАЙЛАН....................144
4.1 Ерөнхий зүйл....................14
4.2 Материаллаг байдал....................14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....................14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................15
4.5.1 Завсрын аудитын талаар....................15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....................166
5.1 Албан шаардлага.................... **Error! Bookmark not defined.**6
5.2 Залруулга....................16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 119

танай ______________-ны №_______________-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.МАЖИГСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн "Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль"-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн "Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль"-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2022 оны төлөвлөгөө нь 2,003,949.0 мянган төгрөг, гүйцэтгэл нь 1,891,228.7 мянган төгрөг 99 хувьтай байна. Улсын төсвөөс гүйцэтгэлээр 1,793,230.3 мянга, орон нутгийн төсвөөс 182,843.0 мянга, нэмэлт санхүүжилтээр 7,152.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,891,228.7 мянган төгрөгийг зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **97,540,644.69** | **118,277,838.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **-** | **16,056,676.38** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 16,056,676.38 |
| 3121 | Төгрөг | - | 16,056,676.38 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 16,056,676.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **97,540,644.69** | **102,221,162.25** |
| 351 | Түүхий эд материал | 1,962,000.00 | 1,962,000.00 |
| 35130 | Эм боох материал | 1,962,000.00 | 1,962,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 95,578,644.69 | 100,259,162.25 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,723,061.91 | 3,169,061.91 |
| 35420 | Аж ахуйн материал | 74,948,856.86 | 71,408,121.86 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 757,525.92 | 1,372,140.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 893,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,149,200.00 | 23,416,838.48 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,601,377,555.92** | **2,594,794,292.24** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,601,377,555.92** | **2,594,794,292.24** |
| 392 | Биет хөрөнгө | 2,549,494,555.92 | 2,541,671,292.24 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,736,816,047.69 | 2,739,791,047.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (422,156,948.04) | (504,490,260.67) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,410,000.00 | 33,410,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,215,000.06) | (23,356,666.78) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 304,621,818.00 | 396,562,188.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (244,783,219.62) | (241,331,040.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 215,521,242.00 | 197,785,742.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (145,839,325.18) | (146,325,589.34) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 73,510,133.00 | 74,003,333.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (24,340,846.94) | (31,829,046.94) |
| 39217 | Ном | 42,950,655.07 | 47,451,585.31 |
| 393 | Биет бус хөрөнгө | 51,883,000.00 | 53,123,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,050,000.00 | 2,550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (905,000.00) | (1,165,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 51,738,000.00 | 51,738,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,698,918,200.61** | **2,713,072,130.87** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 21,913,462.38 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 21,913,462.38 | - |
| 413 | Өглөг | 21,913,462.38 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 8,990,093.52 | - |
| 4136 | Бусад өглөг | 12,923,368.86 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 12,923,368.86 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,677,004,738.23** | **2,713,072,130.87** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,677,004,738.23 | 2,713,072,130.87 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 463,183,325.29 | 463,183,325.29 |
| 51101 | Өмч: - төрийн | 463,183,325.29 | 463,183,325.29 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,924,718,761.70 | 1,960,786,154.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,980,458,566.55 | (774,199,438.91) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (55,739,804.85) | 2,734,985,593.25 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 289,102,651.24 | 289,102,651.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,698,918,200.61** | **2,713,072,130.87** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,637,093,826.84** | **4,780,040,658.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **93,680,421.84** | **2,803,967,358.33** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 93,680,421.84 | 2,803,967,358.33 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 93,680,421.84 | 2,803,967,358.33 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,152,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 93,680,421.84 | 2,796,814,858.33 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,543,413,405.00** | **1,976,073,300.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,441,653,100.00 | 1,793,230,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,793,230,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,441,653,100.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,442,805.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,700,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,742,805.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 94,317,500.00 | 182,843,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 94,317,500.00 | 182,843,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,692,833,631.69** | **2,045,055,065.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,692,833,631.69** | **2,045,055,065.08** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,607,424,266.26 | 1,925,300,691.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,132,559,301.00** | **1,322,012,875.12** |
| 210101 | Үндсэн цалин | 847,736,982.12 | 940,765,471.09 |
| 210102 | Нэмэгдэл | 219,294,667.33 | 314,690,742.58 |
| 210104 | Урамшуулал | 65,527,651.55 | 66,556,661.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **146,152,200.00** | **168,292,288.98** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,232,000.00 | 114,687,266.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,980,100.00 | 13,357,364.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,984,000.00 | 10,860,796.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,894,200.00 | 2,710,403.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,061,900.00 | 26,676,458.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **67,959,823.03** | **84,863,423.92** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,155,647.99 | 19,249,523.78 |
| 210302 | Түлш, халаалт | 47,860,025.04 | 59,753,632.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,944,150.00 | 5,860,268.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,802,452.00** | **29,815,435.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,005,300.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,294,800.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,467,500.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 72,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 426,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,556,200.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,980,652.00 | 29,815,435.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **55,703,075.00** | **78,700,240.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,905,050.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 48,926,925.00 | 78,700,240.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,871,100.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,862,350.00** | **15,943,320.00** |
| 210604 | Урсгал засвар | 27,862,350.00 | 15,943,320.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **719,400.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 719,400.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,605,932.00** | **18,906,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,605,932.00 | 7,152,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 11,753,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **147,059,733.23** | **206,766,708.92** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,327,100.00 | 46,362,765.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,991,695.00 | 18,469,680.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 138,740,938.23 | 141,934,263.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **85,409,365.43** | **119,754,373.14** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 58,829,100.00 | 119,753,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,731,200.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 55,397,900.00 | 119,753,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,700,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 25,791,095.52 | 873.14 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,791,095.52 | 873.14 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 789,169.91 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 789,169.91 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(55,739,804.85)** | **2,734,985,593.25** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(55,739,804.85)** | **2,734,985,593.25** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,543,413,405.00** | **1,983,225,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **7,152,500.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 7,152,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 7,152,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,152,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,543,413,405.00** | **1,976,073,300.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,441,653,100.00 | 1,793,230,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,793,230,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,441,653,100.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,442,805.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,700,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,742,805.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 94,317,500.00 | 182,843,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 94,317,500.00 | 182,843,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,526,570,505.00** | **1,891,228,742.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,526,570,505.00** | **1,891,228,742.62** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,447,952,839.57 | 1,765,090,069.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,123,569,207.48 | 1,331,002,968.64 |
| 210101 | Үндсэн цалин | 838,746,888.60 | 949,755,564.61 |
| 210102 | Нэмэгдэл | 219,294,667.33 | 314,690,742.58 |
| 210104 | Урамшуулал | 65,527,651.55 | 66,556,661.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **146,152,200.00** | **168,292,288.98** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,232,000.00 | 114,687,266.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,980,100.00 | 13,357,364.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,984,000.00 | 10,860,796.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,357,200.00 | 2,710,403.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,598,900.00 | 26,676,458.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **63,929,980.09** | **91,601,406.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,155,647.99 | 19,249,523.78 |
| 210302 | Түлш, халаалт | 41,860,182.10 | 66,491,615.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,914,150.00 | 5,860,268.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,011,800.00** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,989,300.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,294,800.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,467,500.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 72,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 426,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,762,200.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **51,976,275.00** | **79,409,040.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,695,050.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 45,410,125.00 | 79,409,040.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,871,100.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **29,598,350.00** | **19,184,520.00** |
| 210604 | Урсгал засвар | 29,598,350.00 | 19,184,520.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **719,400.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 719,400.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,605,932.00** | **18,906,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,605,932.00 | 7,152,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 11,753,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,389,695.00** | **56,693,445.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 37,912,765.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,389,695.00 | 18,780,680.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **78,617,665.43** | **126,138,673.14** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **52,037,400.00** | **126,137,800.00** |
| **213204** | **Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал** | **1,731,200.00** | **-** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 48,606,200.00 | 126,137,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,700,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 25,791,095.52 | 873.14 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,791,095.52 | 873.14 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **789,169.91** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 789,169.91 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **16,842,900.00** | **91,997,057.38** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **16,842,900.00** | **75,940,381.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 16,842,900.00 | 75,940,381.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 16,842,900.00 | 75,940,381.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 16,842,900.00 | 75,940,381.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(16,842,900.00)** | **(75,940,381.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **16,056,676.38** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **16,056,676.38** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| **C01** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 463,183,325.29 | 289,102,651.24 | 2,092,049,085.13 | 0.00 | 2,844,335,061.66 |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **463,183,325.29** | **289,102,651.24** | **2,092,049,085.13** | **0.00** | **2,844,335,061.66** |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | (111,590,518.58) | 0.00 | (111,590,518.58) |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (55,739,804.85) | 0.00 | (55,739,804.85) |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **463,183,325.29** | **289,102,651.24** | **1,924,718,761.70** | **0.00** | **2,677,004,738.23** |
| **D01** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **463,183,325.29** | **289,102,651.24** | **1,924,718,761.70** | **0.00** | **2,677,004,738.23** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (2,698,918,200.61) | 0.00 | (2,698,918,200.61) |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 463,183,325.29 | 289,102,651.24 | (774,199,438.91) | 0.00 | (21,913,462.38) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 2,734,985,593.25 | 0.00 | 2,734,985,593.25 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **463,183,325.29** | **289,102,651.24** | **1,960,786,154.34** | **0.00** | **2,713,072,130.87** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,004,123,700.00** | **1,967,168,250.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,004,123,700.00** | **1,967,168,250.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,877,811,200.00** | **1,841,030,450.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,356,235,600.00** | **1,331,002,968.64** |
| 210101 | Үндсэн цалин | 1,034,320,500.00 | 949,755,564.61 |
| 210102 | Нэмэгдэл | 285,928,700.00 | 314,690,742.58 |
| 210104 | Урамшуулал | 35,986,400.00 | 66,556,661.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **170,829,400.00** | **168,292,288.98** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 116,359,600.00 | 114,687,266.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,617,400.00 | 13,357,364.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,894,000.00 | 10,860,796.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,723,500.00 | 2,710,403.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,234,900.00 | 26,676,458.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **97,761,800.00** | **91,601,406.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,500,000.00 | 19,249,523.78 |
| 210302 | Түлш, халаалт | 75,345,500.00 | 66,491,615.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,916,300.00 | 5,860,268.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,417,600.00** | **79,409,040.00** |
| 210502 | Хоол, хүнс | 79,417,600.00 | 79,409,040.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,000,000.00** | **22,159,520.00** |
| 210604 | Урсгал засвар | 25,000,000.00 | 22,159,520.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,406,400.00** | **20,406,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,152,500.00 | 7,152,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,253,900.00 | 13,253,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **128,160,400.00** | **128,158,826.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,279,600.00 | 108,278,146.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,880,800.00 | 19,880,680.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **126,312,500.00** | **126,137,800.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 126,312,500.00 | 126,137,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 126,312,500.00 | 126,137,800.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,996,971,200.00** | **1,976,072,426.86** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,996,971,200.00** | **1,976,072,426.86** |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,996,971,200.00 | 1,976,072,426.86 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **16,056,676.38** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэдтөлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадварбүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Сангийн яамны 2023 оын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн

зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-ын удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388, 32-дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” ‘’Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал’’, ‘’Сангийн сайдын 2008 оны Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай’’ 252 дугаар тушаалыг баримтлал болгон бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,153.9 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 16,056.7 | 16,056.7 |
| Бараа материал | 97,540.6 | 102,221.2 | 4,680.5 |
| Үндсэн хөрөнгө | 2,601,377.6 | 2,594,794.3 | (6,583.3) |
| **Нийт хөрөнгө** | **2,698,918.2** | **2,713,072.1** | **14,153.9** |
| Өр төлбөр | **21,913.5** | **0** | **0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,677,004.7 | 2,713,072.1 | 36,067.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,698,918.2** | **2,713,072.1** | **14,153.9** |

Нийт орлого 3,142,946.8 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндэслэн үндсэн хөрөнгө, бараа материалын эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,594,794.3 мянган төгрөг болж, 6,583.3 мянган төгрөгөөр буюу 25.0 хувиар буурч бараа материалын үлдэгдэл 102,221.2 мянган төгрөг болж 4,680.5 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 352,221.4 мянган төгрөг буюу 17.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нэмэгдэл, хоол хүнсний зардал байна. Цалингийн зардал 189,453.6, түлш халаалтын зардал, хоол хүнсний зардал 29,773.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,187,599.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 183,475.7 мянган төгрөгөөр бууруулж, 2,004,123.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхэд 2,004,123.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,793,230.3 мянган төгрөгийг улсын тусгай зориулалтын төсвөөс санхүүжүүлж, орон нутгийн төсвөөс 182,843.0 мянган төгрөг, өөрсдийн үйл ажиллагааны орлогоор 7,152.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 81801- Үдийн цай хөтөлбөр | 126,312.5 | 126,137.8 | 174.7 | 99,8% |
| 2 | 81806-Дотуур байрны үйлчилгээ | 112,339.7 | 108,811.2 | 3,528.5 | 96,8% |
| 3 | 81816- Зөв Монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 71,930 | 71,929.9 | 0.02 | 100% |
| 4 | 81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 11.928.5 | 11,928.1 | 0.4 | 100% |
| 5 | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 1,272,738.7 | 1,263,592.6 | 9,146.1 | 99.3% |
| 6 | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 183,931.7 | 180,724.7 | 3,207.0 | 98,3% |
| 7 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 5,301.6 | 5,301.6 | - | 100% |
| 8 | 80312-Сургалт семинар | 2,650.8 | 2,650.8 | - | 100% |
| 9 | 80823-Эрүүл мэндийг дэмжих | 6,096.8 | 6,096.8 | - | 100% |
| 10 | 81848-Сурах бичиг түрээс | 7,152.5 | 7,152.5 | - | 100% |
| 11 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 122,761.8 | 113,760.9 | 9,000.8 | 100% |
| 12 | 80112-Нийтлэг үйлчилгээ | 80,979.1 | 69,081.2 | 11,897.9 | 100% |
| **НИЙТ** | | 2,004,123.7 | 1,967,168.2 | 36,955.5 | 99% |

Төрийн үйлчилгээний ажилчдын цалин 2022 оны 01 дүгээр сараас орон нутгаас санхүүжиж эхэлсэнтэй холбоотой нийтлэг үйлчилгээний төсөв 11,897.9, тогтмол зардлын төсөв 9,000.8, нийт 20,898.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсоноос төсөв хэмнэгдсэн байна. Улсын төсвийн санхүүжилтийн мөнгөн гүйлгээний эцсийн үлдэгдэл нь 16,056.7 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт төсөв аваагүй байна.

### *3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Миндүг Аудит" ХХК-ийн МНБ,ТМЗ, аудитор С.Энхтөр, аудиторын туслах Ш.Ундрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 16,928.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,849.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд Түлш, халаалтын зардал 11,893.6 мянган төгрөг, гэрэл, цахилгааны зардал 5,093.9 мянган төгрөг, хоол хүнсний зардал 29,773.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Гэрэл цахилгаан, хоол хүнсний зардал: Өмнөх онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж, сургуулийн дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо бага байсантай холбоотойгоор зардал бага гарч байсан бол тайлант онд үйл ажиллагаа хэвийн явагдаж гэрэл цахилгаан 26.5 хувь, хоол хүнсний зардал 37.8 хувиар нэмэгдэхэд гол нөлөөлөл үзүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуульд завсрын аудит хийгдээгүй.

---

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 100% бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3 Албан* шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Албан шаардлага** | 1 | 16,342.0 | 1 | 16,342.0 | 100% |
| **Зөвлөмж** | 4 | 42,828.2 | 4 | 42,828.2 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **59,170.2** | **5** | **59,170.2** | **100.0%** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30,523.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 29,351.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, татварын хэлтэст илүү тайлагнасан ХХОАТ тайланд 1 залруулга хийв.

### 5.1 Залруулга

*1. ХХОАТ-ыг тайлагнахдаа Татварын хэлтэст илүү тайлагнасан байна.*

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ тайланг засуулах хүсэлт илгээж засуулав.

### 5.2 Албан шаардлага

**1.** Нийт 6 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 29,351.1 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалтыг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

**/мянган төгрөгөөр/**

| **Алдааны товч утга** | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн |
| ХХОАТ-ын тайланг татварын хэлтэс илүү тайлагнасныг залруулсан. | 1 | 1,172.4 | | | | | 1 | 1,172.4 | | | | |
| **Нийт** | **1** | **1,172.4** | | | | | **1** | **1,172.4** | | | | |

| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **/мянган төгрөгөөр/** | | | | | | | | | | | | |
| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим төлбөрийн баримтаар батлагдаагүй ажил гүйлгээ гаргасан байна. | 6 | 29,351.1 | | | 1 | 29,351.1 | | | | | | |
| **Дүн** | **6** | **29,351.1** | | | **1** | **29,351.1** | | | | | | |